

**Сургуульд элсэх өргөдөл гаргах/ Шалгалт өгөх**

Элсэх хүсэлтэй сургуульдаа сургуульд элсэх өргөдөл гаргахад шаардлагатай бичиг баримтыг илгээж, шалгалт өгнө. (Японд шалгалт өгөх шаардлагатай бол Японд ирнэ.)

Элсэх хүсэлтэй сургууль (Японд суралцах сургууль)

**Сургуульд элсэх зөвшөөрлийн бичиг хүлээн авах**

Виз мэдүүлэх бичиг баримт бүрдүүлэхэд шаардлагатай болно. Сайтар хадгалаарай.

**Сургуульд элсэх зөвшөөрлийн бичиг илгээх**

Элсэх хүсэлтэй сургууль (Японд суралцах сургууль) нь тэнцсэн элсэгчид сургуульд элсэх зөвшөөрлийн бичгийг илгээнэ.

**Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ (СОЕ) олгохыг мэдүүлэх**

Таны төлөөлөгч (Элсэх хүсэлтэй сургууль гэх мэт) эсвэл та (Японд суралцах хүсэлт гаргагч) орон нутгийн хилийн шалган нэвтрүүлэх хяналтын албанд СОЕ олгохыг мэдүүлнэ.

**Орон нутгийн хилийн шалган нэвтрүүлэх хяналтын алба**

**Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ (СОЕ) хүлээн авах**

Таны төлөөлөгч (Элсэх хүсэлтэй сургууль гэх мэт) рүү Орон нутгийн хилийн шалган нэвтрүүлэх хяналтын албанаас СОЕ-ийг илгээнэ.

**Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ (СОЕ) хүлээн авах, виз мэдүүлэх**

СОЕ хүлээн авсны дараа, виз мэдүүлэхэд шаардлагатай бичиг баримтаа бүрдүүлж, танай улс дахь Япон улсын элчин сайдын яаманд виз мэдүүлнэ.

**Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ (СОЕ) илгээх**

СОЕ олгогдмогц, элсэх хүсэлтэй сургууль (Японд суралцах сургууль) зэрэг нь тань руу СОЕ-ийн эх хувийг илгээнэ.

**Танай улс дахь Японы улсын элчин сайдын яам**

**Японд ирэх, Японы хил нэвтрэх зөвшөөрөл мэдүүлэх**

Хилээр нэвтрэхэд паспорт, виз, СОЕ-ийн эх хувь шаардлагатай. Сургуульд элсэх зөвшөөрлийн бичгээ үзүүлэхийг шаардах тохиолдол байдаг. Нисэх онгоцны буудал дээр хил нэвтрэх зөвшөөрөл хүснэ.

**Орон нутгийн хилийн шалган нэвтрүүлэх хяналтын алба**

Шинчитосэ, Нарита, Ханэда, Чюүбү, Кансай, Хирошима, Фүкүока нисэх онгоцны буудлуудаас хилээр нэвтэрч, оршин суух хугацаа нь 3 сараас дээш бол, хил нэвтрэх зөвшөөрөл гармагц оршин суух үнэмлэх олгогдоно.

**Япон дахь оюутны амьдралын эхлэл!**